



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 7/480

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож,
захиалагчийн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 30 дугаар зүйлийн 30.1, 30.4, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.3, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2.6, Засгийн газрын 2017 оны “Захиалагчийн дүрэм батлах тухай” 170 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг-2024” А/259 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1 Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр батлагдсан Бүрэнхаан цэцэрлэгийн баруун хойд талын хатуу хучилттай авто замаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв хүртэлх хатуу хучилттай зам тавих төсөл арга хэмжээний ажлыг гүйцэтгэгч сонгох ХӨАХААГ/20240101175 дугаартай 599,281,624 (Таван зуун ерэн есөн сая хоёр зуун наян нэгэн мянга зургаан зуун хорин дөрөв) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Силк Трасс” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанитай гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Силк Трасс” ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, ажлын үе шатны хяналт хэрэгжүүлэх, зураг төслийг хүлээн авах, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх чиг үүрэг бүхий захиалагчийн төлөөлөгч, ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

Б.Оюунтуяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Б.Мөнхзул

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
өмчийн удирдлага, зохицуулалт
хариуцсан мэргэжилтэн)

Э.Наранчимэг

(Хөвсгөл барилга захиалагчийн төвийн
автозамын хяналтын инженер)
("Силк Трасс" ХХК-ийн захирал)

А.Золзаяа

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Д.Сандагдорж

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн Дэд бүтцийн
бодлого үйл ажиллагааг зохион

3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр батлагдсан Бүрэнхаан цэцэрлэгийн баруун хойд талын хатуу хучилттай авто замаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв хүртэлх хатуу хучилттай зам тавих төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлд үе шатанд хийх захиалагчийн хяналтыг "Силк Трасс" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх, уг гэрээг дүгнэх, ил далд ажлын акт, хатуу хучилттай авто замын гүйцэтгэлийг тус тус баталгаажуулах, авто замын ашиглалтад оруулахад шаардлагатай баримт бичгийг бэлтгэж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэх, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн тайлан авто замын ажлын гэрээний хэрэгжилттэй холбоотой баримт бичгийг архивын нэгж болгон Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээт ажлын үе шатны хяналтыг хийж, баталгаажуулсан техник хяналтын нэгдсэн дүгнэлт, зохиогчийн дүгнэлт, авто замын ашиглалтад хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр архивлан Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Даваасамбуу)-д тус тус даалгасугай.

4. Бүрэнхаан цэцэрлэгийн баруун хойд талын хатуу хучилттай авто замаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв хүртэлх хатуу хучилттай зам тавих гүйцэтгэгч сонгоход хэрэгжүүлэх шаардлагатай зардлыг гэрээний дагуу "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-т Бүрэнхаан цэцэрлэгийн баруун хойд талын хатуу хучилттай авто замаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв хүртэлх хатуу хучилттай зам тавих төсөл арга хэмжээний ажлыг ашиглалтад хүлээн авах ажиллагаатай холбогдон гарах зардлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт шилжүүлэхийг Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог)-т тус тус зөвшөөрсүгэй

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

